

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2019 оны 08 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Зөвлөх үйлчилгээний дэлгэрэнгүй болон хураангуй жагсаалтыг бүрдүүлэх санамж

Энэхүү зарлалыг зөвлөхийн дэлгэрэнгүй жагсаалт бэлтгэх зорилгоор өдөр тутмын сонин хэвлэл болон Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудсанд нийтэлнэ. Захиалагч тухайн зарын дагуу саналаа ирүүлсэн зөвлөх болон хуулийн 36.5 зүйлд заасан бусад этгээдийн нэрсээс бүрдсэн дэлгэрэнгүй жагсаалтыг гаргана.

Дэлгэрэнгүй жагсаалтад хамрагдсан зөвлөхүүдээс хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлага болон захиалагчаас тогтоосон чадавхийн үзүүлэлтийг хангасан 3 ба түүнээс дээш зөвлөхийг захиалагч сонгож, хураангуй жагсаалт гаргана.

Хураангуй жагсаалтад орсон зөвлөхөд бэлтгэсэн тендерийн баримт бичгийг ажлын даалгаврын хамт хүргүүлнэ.

1. **Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар** нь **Баянзүрх дүүргийн 23-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 4-р хороо, Хан-Уул дүүргийн 9-р хорооны гэр хорооллын дундын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийг хүргэх “Дэд бүтцийн төв”-ийн иж бүрэн ажлын зураг төслийг боловсруулах ажлыг** хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь **зөвлөхийн урьдчилсан мэдүүлэг** болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ:

- Улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар ирүүлэх
- Одоо хийж байгаа ажлын талаарх мэдээлэл /гэрээний хуулбар/
- Хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлагын талаарх мэдээлэл, нотлох баримт /гэрээ, ажил хүлээлцсэн акт, тогтоол, шийдвэр/
- Тус ажлыг хийж гүйцэтгэх инженер техникийн ажилтны дэлгэрэнгүй мэдээлэл, CV
- Хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлагын талаарх мэдээлэл, нотлох баримт /гэрээ, ажил хүлээлцсэн акт, тогтоол, шийдвэр/ ирүүлэх бөгөөд тендерийн үнэлгээний дүнд харгалзана үзнэ.
- Тусгай зөвшөөрөл шаардагдана. Үүнд:
Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог
-1.2.1. 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)
-1.2.4. Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл
-1.2.5. Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10 кВ хүртэл) Дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн

зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл

-1.2.6. Техник, эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв

-1.3.1. Дулааны шугам гол сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг

-1.3.3. Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /35 кВ хүртэл/

Эсвэл;

-ЗТ-2.1 Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)

-ЗТ-3.4 Ус хангамж, ариутгах татуургын гол /магистраль/ шугам сүлжээ түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг

-ЗТ-3.5 Дулааны шугам гол /магистраль/ сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг

-ЗТ-3.6 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг

-ЗТ-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

-ЗТ-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

-ЗТ-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл, Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл

-ЗТ-6.4 Барилга байгууламжийн дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл

-ЗТ-11.1 Барилга байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, төсөв

4. Ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгэх зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцох боломжтой эсэх: **Зөвшөөрнө**

5. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2019 оны 09 дүгээр сарын 9-ны өдрийн 10 цагаас** өмнө Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

6. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (**pdf**)-ээр илгээнэ.

Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn -ээр банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15,
Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 7 дугаар давхар,
Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газар,
Утас: 70110733**